

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭНТИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН СУДЛАХ МУЗЕЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2024/143/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2024 он
Цахим хуудас: www.open.audit.mn

Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkhegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12 Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.04 № 258
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Орон нутгийн судлах музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орон нутгийн судлах музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө 5,008.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 16.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, халаалтын төлбөрийг 11.1 сая төгрөгөөр илүү төлж халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, цалин, ээлжийн амралтын хоногийг давхардуулан 1.0 сая төгрөг, тушаал шийдвэрийг үндэслэлгүй 0.5 сая төгрөг, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 2.6 сая төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 20.1.2, 20.2.5 дахь заалт болон оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

232430292

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн урьдчилан тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 7.5 сая төгрөг, бараа материал 16.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө 4,907.3 сая төгрөг, өр төлбөр 1.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд улсын төсвөөс 477.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 144.4 сая мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлого 2.8 сая төгрөг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаандаа 479.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 5,249.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 209.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 4.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,035.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Үндсэн хөрөнгийг орлогоор бүртгээгүй орхигдуулсан, зөрүүтэй илэрхийлсэн зэрэг 209.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.

Тухайн байгууллага анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай зохион байгуулахад тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатайг анхаарах нь зүйтэй.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, 90 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,023,505.99	23,545,514.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,368,486.99	7,532,701.29
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,368,486.99	7,532,701.29
31210	Төгрөг	6,368,486.99	7,532,701.29
31211	Төрийн сангийн харилцах	6,365,182.99	7,529,397.29
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,304.00	3,304.00
34	УРЬДЧИЛГАА	0	0
35	БАРАА МАТЕРИАЛ	15,655,019.00	16,012,813.00
35400	Хангамжийн материал	15,655,019.00	16,012,813.00
35420	Аж ахуйн материал	11,982,119.00	11,291,013.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	275,000.00
35450	Барилгын засварын материал	3,672,900.00	0
35470	Бусад хангамжийн материал	0	4,446,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,583,554,032.38	4,939,677,351.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,583,554,032.38	4,939,677,351.34
39200	Биет хөрөнгө	4,405,816,532.38	4,761,939,851.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,344,695,348.27	3,344,695,348.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	-150,184,212.32	-208,802,142.48
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	265,642,704.00	646,669,488.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,744,710.71	-55,982,620.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,629,058.00	60,290,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,679,237.19	-1,946,137.94
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	965,561,480.00	971,411,480.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,937,769.00	5,937,769.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-41,666.67	-333,333.36
39300	Биет бус хөрөнгө	177,737,500.00	177,737,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	177,737,500.00	177,737,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,605,577,538.37	4,963,222,865.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,952,365.59	1,692,810.07
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,952,365.59	1,692,810.07
41300	Өглөг	2,952,365.59	1,692,810.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,952,365.59	1,692,810.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,602,625,172.78	4,961,530,055.56
51	Засгийн газрын хувь оролцоо	4,602,625,172.78	4,961,530,055.56
51100	Засгийн газрын оруулсан капитал	279,495,619.00	279,495,619.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	279,495,619.00	279,495,619.00
51200	Хуримтлагдсан үр дүн	3,562,865,359.35	3,921,771,242.13
51210	Өмнөх үеийн үр дүн	3,562,865,359.35	3,562,718,404.35
51220	Тайлант үеийн үр дүн		359,052,837.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	760,264,194.43	760,263,194.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,605,577,538.37	4,963,222,865.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,143,407,339.09	1,086,568,063.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,708,987,739.09	464,435,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,708,987,739.09	464,435,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,072,500.00	464,435,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,072,500.00	2,020,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	800,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,676,886,448.09	461,615,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,028,791.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	434,419,600.00	622,133,063.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	251,228,700.00	477,687,963.02
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	251,228,700.00	477,687,963.02
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	183,190,900.00	144,445,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,190,900.00	144,445,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	469,342,520.25	725,296,192.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,342,520.25	725,296,192.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,915,096.08	673,965,425.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,475,290.65	375,051,632.30
210101	Үндсэн цалин	120,009,221.61	275,873,691.08
210102	Нэмэгдэл	29,913,450.04	42,122,566.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,057,633.25	20,200,329.54
210104	Урамшуулал	3,494,985.75	36,855,045.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,239,537.63	45,601,022.63
210201	Тэтгэврийн даатгал	19,362,367.83	31,278,037.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,290,370.00	3,679,708.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,547,700.00	2,834,499.86
210204	Ажилгүйдлийн даатгал	458,100.00	724,990.48
210205	Эрүүл мэндийн даатгал	4,580,999.80	7,083,786.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,263,090.09	116,865,837.32
210301	Гэрэл, цахилгаан	7,117,995.09	19,252,662.32
210302	Түлш, халаалт	86,039,795.00	94,199,545.00
210303	Цэвэр, бохир ус	3,105,300.00	3,413,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,428,262.00	6,765,025.37
210401	Бичиг хэрэг	11,312,870.00	263,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,437,400.00	2,716,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,611,540.00	1,342,585.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,066,452.00	1,741,580.00
210408	Бараа материал акталсны зардал	0	631,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,500.00	7,927,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	2,065,500.00
210604	Урсгал засвар	900,500.00	5,862,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,050,000.00	320,000.00
210702	Дотоод албан томилолт	1,050,000.00	320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,926,000.00	8,309,109.90

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,926,000.00	7,785,467.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	523,642.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,632,415.71	113,125,248.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	3,752,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,632,415.71	109,372,648.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,427,424.17	51,330,766.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,915,700.00	26,244,754.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,197,700.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	25,544,754.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	718,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	40,511,724.17	25,086,012.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,511,724.17	25,086,012.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,674,064,818.84	361,271,870.45
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	2,219,032.67
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	2,219,032.67
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,674,064,818.84	359,052,837.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	436,658,159.74	624,953,063.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,090,604.74	2,820,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,090,604.74	2,820,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,090,604.74	2,820,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,090,604.74	2,020,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	434,567,555.00	622,133,063.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	251,228,700.00	477,687,963.02
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	251,228,700.00	477,687,963.02
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	183,190,900.00	144,445,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,190,900.00	144,445,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	147,955.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	147,955.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,289,672.75	617,688,848.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,289,672.75	617,688,848.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,257,248.58	566,358,082.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,035,282.75	374,508,095.54
210101	Үндсэн цалин	174,225,596.61	275,330,154.32
210102	Нэмэгдэл	33,143,665.40	42,122,566.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,589,537.99	20,200,329.54
210104	Урамшуулал	11,076,482.75	36,855,045.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,629,800.00	47,552,069.91
210201	Тэтгэврийн даатгал	19,468,300.00	33,229,084.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,290,300.00	3,679,708.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,832,100.00	2,834,499.86
210204	Ажилгүйдлийн даатгал	458,100.00	724,990.48
210205	Эрүүл мэндийн даатгал	4,581,000.00	7,083,786.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,161,175.83	116,865,837.32
210301	Гэрэл, цахилгаан	7,016,080.83	19,252,662.32
210302	Түлш, халаалт	86,039,795.00	94,199,545.00
210303	Цэвэр, бохир ус	3,105,300.00	3,413,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,718,390.00	5,095,385.37
210401	Бичиг хэрэг	932,170.00	263,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,714,800.00	2,716,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,624,020.00	1,342,585.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,287,400.00	703,400.00
2105	Нормативт зардал	322,600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	322,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	8,951,084.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	5,694,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	763,034.00
210604	Урсгал засвар	0.00	2,493,250.00
2107	Томилолт, зочны зардал	1,050,000.00	320,000.00
210702	Дотоод албан томилолт	1,050,000.00	320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,840,000.00	10,963,509.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,840,000.00	10,439,867.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	523,642.90

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,102,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,102,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,032,424.17	51,330,766.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,520,700.00	26,244,754.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,197,700.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	25,544,754.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,323,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	40,511,724.17	25,086,012.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,511,724.17	25,086,012.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,368,486.99	7,264,214.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,000,000.00	6,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	6,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	6,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	6,100,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,000,000.00	-6,100,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,368,486.99	1,164,214.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,368,486.99
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,368,486.99	7,532,701.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	279,495,619.00	760,264,194.43	-1,111,199,459.49	-71,439,646.06
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,495,619.00	760,264,194.43	-1,111,199,459.49	-71,439,646.06
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,674,064,818.84	4,674,064,818.84
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,495,619.00	760,264,194.43	3,562,865,359.35	4,602,625,172.78
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,495,619.00	760,264,194.43	3,562,865,359.35	4,602,625,172.78
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-1,000.00	-146,955.00	-147,955.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	3,562,718,404.35	4,602,477,217.78
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	359,052,837.78	359,052,837.78
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	279,495,619.00	760,263,194.43	3,921,771,242.13	4,961,530,055.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489,639,500.00	479,343,748.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,639,500.00	479,343,748.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,326,700.00	453,098,994.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,554,100.00	374,508,095.54
210101	Үндсэн цалин	291,089,200.00	275,330,154.32
210102	Нэмэгдэл	32,148,700.00	42,122,566.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,632,000.00	20,200,329.54
210104	Урамшуулал	34,684,200.00	36,855,045.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,858,700.00	47,552,069.91
210201	Тэтгэврийн даатгал	32,636,000.00	33,229,084.97
210202	Тэтгэмжийн даатгал	3,805,800.00	3,679,708.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,044,600.00	2,834,499.86
210204	Ажилгүйдлийн даатгал	761,100.00	724,990.48
210205	Эрүүл мэндийн даатгал	7,611,200.00	7,083,786.09
2104	Хангамж, бараа материалын зардал	5,450,400.00	5,095,385.37
210401	Бичиг хэрэг	527,000.00	263,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,720,000.00	2,716,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000.00	1,342,585.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	703,400.00	703,400.00
2105	Нормативт зардал	222,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	222,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,494,800.00	6,457,834.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,694,800.00	5,694,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	763,034.00
2107	Томилолт, зочны зардал	360,000.00	320,000.00
210702	Дотоод албан томилолт	360,000.00	320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,251,100.00	17,063,509.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,621,100.00	16,539,867.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	630,000.00	523,642.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,135,600.00	2,102,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,135,600.00	2,102,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,312,800.00	26,244,754.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,312,800.00	26,244,754.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,544,800.00	25,544,754.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	700,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	489,639,500.00	480,507,963.02
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	477,688,100.00	477,687,963.02
310001	Улсын төсвөөс санхүүжих	477,688,100.00	477,687,963.02
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,951,400.00	2,820,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,020,000.00	2,020,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	800,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,131,400.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,365,182.99

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	7,529,397.29
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	24.00
650006	Соёл урлагийн салбарын терийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	11.00	11.00
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 209,584.7 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл дэлгэрэнгүй журналаас 7,145.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.
2. Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 4,109.3 мянган төгрөгөөр төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
3. Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 198,330.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан.

Аудитаар нийт 5,040,143.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 4,581.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,035,561.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Цалин, ээлжийн амралтын хоногийг давхардуулан тооцож 1,022.6 мянган төгрөг, тушаал шийдвэрийг үндэслэлгүй ээлжийн амралтын хоногийг илүү тооцож 952.5 мянган төгрөг, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг хавсран ажиллах албан тушаалын үндсэн цалингаас бодож олгоогүй 2,606.5 мянган төгрөг зэрэг нийт 4,581.6 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

5.2 Албан шаардлага

1. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө 5,008,424.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 16,000.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, баримтжуулаагүй
2. Халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 11,137.5 мянган төгрөгөөр илүү төлсөн

5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг зөрүүтэй илэрхийлсэн	2	11,254.7			2	11,254.7	2	11,254.7				
Үндсэн хөрөнгийг орлого аваагүй	1	198,330.0	1	198,330.0			1	198,330.0				
Дүн	3	209,584.7	1	198,330.0	2	11,254.7	3	209,584.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Халаалтын зардал илүү төлсөн	1	11,137.5			1	11,137.5						
Хөрөнгө тоолоогүй	1	5,024,424.4			1	5,024,424.4						
Цалин илүү олгосон	1	4,581.6	1	4,581.6								
ДҮН	3	5,040,143.5	1	4,581.6	2	5,035,561.9						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчилгүй	0	0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зөрчилгүй	0	0						